



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 756

Улаанбаатар хот

Хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтгүй байгаа, 28,620,000.00 (хорин найман сая зургаан зуун хорин мянган) төгрөгийн балансын үнэ бүхий (1908 м/кв) биет бус хөрөнгө газар эзэмших эрхийг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч, Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газарт эзэмшүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Э.Түвшинзаяа, Говьсүмбэр аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Болд-Эрдэнэ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор биет бус хөрөнгийг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Газрыг Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын нэр дээр баталгаажуулан, улсын төсвийн (орон нутгийн) хөрөнгөөр “Ахмадын ордон” барихаас өөр зориулалтаар ашиглахгүй байх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.


3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
123007315
35-r_huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны дугаар сарын 28-ны өдрийн
дугаар тогтоолын хавсралт

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ДАНСНААС ХАСЧ, ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр, байршил	Хэмжих нэгж (метрквадрат)	Нэгж балансын үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ (төгрөг)	Хүлээн авч бүртгэх байгууллага
1	Биет бус хөрөнгө (газар эзэмших эрх) Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум 2-р баг Өндөр худгийн зүүн талд	1908	15,000.00	28,620,000.00	Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газар
НИЙТ ДҮН			15,000.00	28,620,000.00	
				(хорин найман сая найман зуун хорин мянга)	